



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2023 оны 03 сарын 15 өдөр

Дугаар А/139

Булган сум

**Үнэлгээний хороо байгуулах тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, 47.4 дэх заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Хуралдааны 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн XIV/01 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих Соёлын байгууллагуудын тавилга, тоног төхөөрөмжийг нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны

дарга: Т.Баттулга (Орон нутгийн өмчийн газрын дарга)

Гишүүд: Б.Мягмарсүрэн (Аймгийн Засаг даргын Тамгын газрын  
Нийгмийн бодлогын хэлтсийн мэргэжилтэн)

Д.Уламбаяр (Орон нутгийн өмчийн газрын ахлах  
мэргэжилтэн)

Иргэний төлөөлөл: О.Буянбат (Булган сумын иргэн)

Нарийн бичгийн дарга: Б.Эрдэнэтуяа (Орон нутгийн өмчийн газрын худалдан  
авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

2.Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.АРИУН-ЭРДЭНЭ

6323010090